



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/146

Чингис хот

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу үр тарианы усалгаатай тариалангийн зориулалттай газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан С.Энхчимэг-д холбогдох бичиг баримтыг үндэслэн газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад дурдсанаар 1 иргэний 1 нэгж талбарыг шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэдэд газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын мэргэжилтэн (Ж.Эрхэмбаяр)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2023 оны 101 тоот захирамжийн дээрх иргэдэд холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 24-ны өдрийн 01/46
дугаар захирамжийн хавсралт

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх нэрсийн жагсаалт

Д/ д	Шилжүүлсэн хүний эцэг/эх/- ийн нэр, нэр	Газрын зориулалт	Газрын хэмжээ	Эзэмшил газрын байршил	Шилжүүлэн авсан иргэн ААНБ-ын нэр	Хугацаа	Шилжүүлэх үндэслэл
1	Сүх-Очир Энхчимэг /СЮ92082604/	Гэр орон сууц, хашааны газар	699 м2	Хэнтий, Хэрлэн 2-р баг, Булаг, Нисэх 14-2	Эрдэнэцогт Уранчимэг /СЮ89082101 /	52	Эрх шилжүүлэх гэрээ